

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн профессор,
хурандаа Г. Эрдэмээ*

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕД ШУУРХАЙ ШТАБЫН ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улс ардчилсан нийгмийг сонгон зах зээлийн эдийн засагт шилжин 20 гаруй жил болох хугацаанд нийгмийн сэтгэл зүй өөрийн зүй тогтлоороо зарим талаараа хөгжсөн ч нөгөө талаар доройтсон үйл явц өрнөж та бидний сэтгэл эмзэглүүлсэн асуудал өсөн нэмэгдсээр байна. Тухайлбал, нийгмийн аль ч давхаргад хамаарагдах хүн зохион байгуулалттайгаар, орчин үеийн техник хэрэгслийн тусламжтай, их хэмжээний хохиролтой гэмт хэргийг урьдаас нарийн төлөвлөн үйлдэж, шүүхээр шийтгэгдэн ял эдлэх болсноор хорих ангид үүсэх аюул занал тэр хэмжээгээр өсөн нэмэгдэж байна. Энэхүү хор аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд сүүлийн жилүүдэд Тогтоол гүйцэтгэх газраас тодорхой тооны хорих ангиудад хорих ангийн дарга, дэд дарга, төлөөлөгч нарыг оролцуулан “команд-штабын сургалт”-ыг нэгдсэн байдлаар зохион байгуулан явуулж, онцгой нөхцөл байдалд ажиллах арга зүйн зөвлөгөө өгч байгаа нь сайшаалтай ажлуудын нэг яах аргагүй мөн.

Хорих ангиудад бүртгэгдэж байгаа онцгой нөхцөл байдалын талаар судлахад ихэнх нь хорих ангиас ялтан бүлэглэн болон ганцаар оргон зайлсан тохиолдлыг хамруулсан байх бөгөөд, хуруу дарам тоотойгоор ялтны зүгээс нийтийг хамарсан үл захирагдах байдал үзүүлэн эсэргүүцсэн байдаг.

Эдгээр тохиолдол бүрт хорих анги болон түүний дээд шатны удирдах байгууллагад тухайн гэмт явдлын аюулын цар хүрээ, нийгэмд учруулах хохирлын хэмжээнээс хамааран шуурхай штаб байгуулагдан ажиллаж, ард иргэдэд учруулж болох хор аюулыг арилгах, нийгмийн аюулгүй байдлыг хангах өөрийн үүргээ амжилттай хэрэгжүүлсээр иржээ. Гэсэн хэдий ч ШШГБ-д онцгой нөхцөл байдлын /хямралт байдал/ үед ажиллах шуурхай штабын тухай ойлголтыг бүрэн дүүрэн шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааж тодорхойлон нэгдсэн ойлголт болгон хэрэгжүүлэх талд учир дутагдалтай байна уу? гэж үзэхээр байна. Хэдийгээр онцгой нөхцөл байдлын үед хорих ангийн дарга, дэд дарга нарын үүргийг¹ судлаачид тодорхойлсон ч шуурхай штабын өөрийн үндсэн үүргийг тодорхойлох зайлшгүй шаардлага урган гардаг.

Шуурхай штабын үүргийн талаарх эрх зүйн үндэс мөн тодорхой бус, хангалтгүй байгааг дурьдах нь зүйтэй.

Иймээс та бүхэнтэй ШШГБ дахь шуурхай штабын үүргийн талаар санал бодлоо солилцохоор дараах асуудлыг дэвшүүлэн тавьж байна. ОХУ болоод хуучин социалист орнуудад “шуурхай штаб” хэмээх энэхүү ухагдахууны хүрээнд нэгдсэн ойлголт бий болсон байдаг. Манай улсын хувьд цэргийн байгууллагууд болох

¹ Ю.Сэрсэнжав. Хорих ял эдлүүлэх байгууллагын харуул хамгаалалт. УБ.: Түмэн үсэг ХХК. 64 дэх тал.

зэвсэгт хүчин, хил хамгаалах байгууллагад энэ бүтэц шаардлагагүй байдаг нь мэргэжлийн чиг үүрэгтэй “штаб” ажиллаж байдагт оршино.

Нэр зүйн хувьд авч үзвэл “штаб” хэмээх үг нь дэлхийн аль ч улсад нэг утгаар ойлгогдож байна. Хүн бий болсон цагаасаа эхлэн өөрийн эзэмшлийг тэлэх сонирхлын үүднээс хоорондоо дайсагналцан тэмцэлдсээр ирсэн. Хүй нэгдэл болоод боолын нийгмийн үед “штаб” гэх ойлголт байгаагүй бөгөөд феодалын нийгмийн үеэс дайны талбарт цэрэг, байлдааны ажиллагаанд оролцох нэгж, салбарууд нэмэгдэж, ач холбогдол өссөнөөр тэдгээрийг нэгтгэн зохион байгуулах үүрэг бүхий тодорхой удирдлагын нэгж ажиллаж эхэлжээ.

Харинудирдлагын энэхүү байгууллага нь анх оросын армид ХҮИИ зууны үед армийн дээд командлагчийн дэргэд байгуулагдсаныг эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн үлдээжээ. Түүний бүрэлдэхүүнд их буу, морин явган цэргийн дарга, инженерүүд, оперативийн хэсэг /квартирмейстер/, бэлтгэгч цэргийн шүүхийн хэсэг, шаардагдах тооны туслахуудын хамтаар ордог байсан байна¹

Гэхдээ түүнээс өмнө улс орнуудын цэрэг, байлдааны ажиллагаанд штабтай нэг адил үүргийг гүйцэтгэдэг ч өөр өөрөөр нэрлэгдэж байсан байгууллага, нэгжүүд ажиллаж байсан нь дамжиггүй. Бидний хувьд ч гэсэн Их Монгол Улсыг байгуулсан эзэн Чингис хааны үед “илдэч”-ийн газар² хэмээн нэрийдэж байсан байгууллага нь штабын хэлбэрийг бүрэн агуулж байжээ.

Цэргийн шинжлэх ухааны хөгжлийн явцад “штаб” хэмээх ойлголт нь нэгэнт өөрийн гэсэн байр сууриа эзэлж, түүний гүйцэтгэх үүргээс шалтгаалан:

стратегийн
оперативын
тактикийн

гэж ангиллаж³тус бүрт үүргүүдийг нарывчлан зааж тодорхойлжээ. Тухайлбал орчин үед батальоны штаб дараах үүргүүдийг гүйцэтгэдэг. Үүнд:

- батальоны салбаруудын байнгын бэлэн байдлыг хангах;
- шаардлагатай мэдээнүүдийг тасралтгүй цуглуулж, дүн шинжилгээ хийх, газар орон ба эсрэг байгаа дайсан, түүний боломж, галын хэрэгсэл ялангуяа танк эсэргүүцэх хэрэгслийн байрлалыг нарийвчлан судлах;
- батальоны захирагчаас үндэслэлтэй шийдвэр цаг тухайд нь гаргахын тулд тактикийн шаардлагатай тооцоонууд, буй болсон цагийн байдлаас хийсэн дүгнэлт болон саналаа бэлтгэх;
- захирагдсан болон хавсрагдсан салбаруудад байлдааны үүргийг цаг тухайд нь хүргэх;
- байлдаанд байнгын нягт харилцан ажиллагааг хангах;
- байлдааны хангалтыг зохион байгуулах. Үүнд: тагнуул, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах, өнгөлөн далдлалт, инженерийн болон химийн хангалт, хориглон хамгаалалт, түүнчлэн техникийн болон ар талын хангалт;
- салбаруудын тавигдсан үүргийг биелүүлж байгаад тасралтгүй хяналт тавих ба тэдгээрт шаардлагатай тусалцаа үзүүлэх;

¹ Б.Түмэн. Байлдааны нөхцөлд ерөнхий цэргийн штабуудын алба. УБ. 2003. 5 дах тал.

² Ж.Базарсүрэн. Морь-маршал-жанжин штаб /Цэргийн шинэчлэл сэтгүүл. 2013. №04.

³ Б.Түмэн. мөн тэнд. 15 дах тал.

- батальоны командын-хянах байрыг дэлгэх, төхөөрөмжлөх ба түүнийг шилжүүлэх ажил, хориглон хамгаалалтыг зохион байгуулах;
- захирагдсан, хавсрагдсан болон дэмжигч салбарууд, хөршүүд болон дээд штабтай холбоог зохион байгуулж, хангах;
- салбаруудыг далдуур удирдлагаар хангах;
- захирагдсан, хавсрагдсан, дэмжигч болон харилцан ажиллагч салбаруудад цагийн байдлын тухай шинэ мэдээнүүдийг цаг тухайд нь хүргэх;
- бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, бүх төрлийн галт хэрэгсэл, байлдааны техник болон тээврийн хэрэгслийн тооцоог хөтлөх, авч явах материал хэрэгслийн нөөц, салбарууд болон батальоны офицеруудын цацраг идэвхт хордолтын тооцоог хөтлөх;
- батальоны байрлалын районд, түүнчлэн төрөл бүрийн тээвэрлэлтийн үеийн журмыг сахиулах ажиллагааг хангах;
- мэдээ, илтгэл болон дээд штабт явуулах захиалгыг цаг тухайд нь өгөх, болох гэж байгаа байлдааны ажиллагааны районы байр зүйн зураг /бүдүүвч, агаарын фото зураг/, бусад шаардлагатай баримт бичгүүдийг хүлээн авах ба тэдгээрээр батальоны салбаруудыг хангах;
- батальоны бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн байдлыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, улсын ба цэргийн нууцыг хадгалах ажиллагааг хангах;
- байлдааны туршлагыг судлан нэгтгэн дүгнэж, батальоны бие бүрэлдэхүүнд хүргэх эдгээр үндсэн үүргүүд ордог байна¹.

Штаб нь дан ганц цэргийн шинжлэх ухааны ойлголт болохоос гадна цэрэгжсэн тусгайлсан чиг үүргүүдийг хэрэгжүүлэгч байгууллагуудад ч мөн хэрэглэгдэх болсон билээ. Тухайлбал ОХУ-ын Дотоод явдлын байгууллага нь онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах шуурхай штабын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бие бүрэлдэхүүний цугларалтыг зохион байгуулах, шуурхай байдалд үнэлэлт дүгнэлт өгч өөрчлөлтийн төлөвийг тодорхойлох, тагнуулын ажиллагааг зохион байгуулах, дэглэмийн хязгаарлалт хийх, тусгай ажиллагаа явуулах, хүч хэрэгслийн харилцан ажиллагааг зохион байгуулах байдаг хэмээгээд үүргүүдийг нь дараахь байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- мэдээллийг цуглуулах болон нарывчлан тодотгох ажиллагааг хангах;
- нөхцөл байдлын өрнөлийг дүгнэх, урьдчилан тооцоолох
- хүч, хэрэгслийг ажиллагаанд оруулахад бэлтгэн урьдчилсан захирамж гаргах
- бүлгүүдийг шуурхай байгуулах ажлыг зохион байгуулж, удирдах
- дээд шатны шуурхай штабтай харилцан ажиллагааг хангах, мөн түүнчлэн гүйцэтгэх засаглалын байгууллагуудын хүч хэрэгслийг татан оролцуулах
- бүрэлдсэн нөхцөл байдлын талаар дотоод хэргийн байгууллагын зохих удирдлагыг мэдээллээр хангах
- шийдвэр гаргахад шаардагдах санал болон тооцоонуудыг бэлтгэх
- шуурхай штабын удирдлагын шийдвэрийг хэлбэржүүлэх, тэдгээрийг бие бүрэлдэхүүнд хүргэх болон хэрэгжилтийг хянах ажиллагааг хангах

¹ Б.Түмэн. Байлдаанд батальоны штабын ажил. УБ. 2003. 6 дах тал.

- хүч, хэрэгслийн бүлэглэн шилжүүлэлтийг зохион байгуулах, тэдгээрийг томилгоот шуурхай ажиллагаа болон байлдааны ажиллагаанд ашиглах

- дотоод хэргийн байгууллагын дээд шатны шуурхай штабад мэдээ, мэдээллийг бэлтгэх үүрэгтэй бол

Шуурхай ажиллагааны /байлдааны/ үүргийг гүйцэтгэх шатанд, нөхцөл байдал эрс хүндэрсэнтэй холбогдуулан шуурхай штаб нь нэмэлт үүргүүдийг хэрэгжүүлдэг¹.

Дээрхи цэргийн болон цагдаагийн байгууллагуудын онцгой нөхцөл байдалд штаб болон шуурхай штабын гүйцэтгэх үүргүүдийг харьцуулан хорих ангид шуурхай штабыг “Хорих ангид онцгой нөхцөл байдал үүссэн үед хүн, хүч, техник хэрэгслийн хуваарилалт хийх, салбар нэгж, бүлгүүдийн харилцан ажиллагааг тасралтгүй удирдах, хяналт тавих үүрэг бүхий зохион байгуулалтын удирдлагын томилгоот бүрэлдэхүүн” гэж ойлгож болох ба гүйцэтгэх үүргүүдийг доорх байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд:

- штабын даргаас хорих ангид тухайн нөхцөл байдалд ажиллах ажиллагааны талаар шийдвэр гаргахад шаардагдах мэдээ, мэдээлүүдийг нэгтгэн танилцуулах

- бүлгүүдийг шуурхай байгуулж, удирдах

- бүлгүүдийн нягт харилцан ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх

- бүх талын хангалтын ажлыг удирдан зохион байгуулах /гүйцэтгэх ажил/

- бүлгүүдийн ажиллагаанд тасралтгүй хяналт тавьж шаардлагатай тохиолдолд туслалцаа, дэмжлэг үзүүлэх

- дээд шатны байгууллагыг /Удирдлагын шуурхай штабыг/ тухайн нөхцөл байдлын талаар мэдээллээр хангах

- бүлгүүдэд шаардлагатай мэдээллийг цаг тухайд хүргэх, хүлээн авах

- бүлгүүд болон бусад эх сурвалжаас ирж байгаа мэдээ, мэдээллийг бүртгэн хөтлөх

- бүлгүүдэд гарч ажиллах хүн, хүчний хуваарилалт хийх, төлөвлөх

- галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, хуваарилалт хийх

- автомашин, өөрөө явагч техникийн хөдөлгөөнийг зохицуулах

- ирж байгаа мэдээ, мэдээлэлд дүгнэлт, анализ хийж цаашдын төлөвийг тодорхойлох

- аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг авах нийтлэг үүргүүд хэрэгжүүлэх бөгөөд тулгамдсан ажиллагааны үед удирдлагын шуурхай тасралтгүй байдлыг хангах үүрэг хүлээнхээр байгаа болно. Хорих анги нь аюулыг өөрийн хүч, хэрэгслээр даван гарах бололцоогүй нөхцөл байдал хүндэрсэн үед дараах үүргүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- захирагдсан салбаруудтай болон харилцан ажиллагаатай байгууллагуудтай тогтвортой, шуурхай холбоотой байж тасралтгүй удирдлагаар хангах

¹ ОХУ-ын ДХЯ-ны сайдын 2002.9.10-ны өдрийн №870 тушаал. “ОХУ-ын ДХЯ-ны дотоодын цэрэг, цагдаагийн байгууллагын онцгой нөхцөл байдлын үед ажиллах дүрэм.

- цагийн байдлын мэдээллийг байнга цуглуулж нэмэгдэн үүсч байгаа цагийн байдалд дүн шинжилгээ хийж, хүч хэрэгслийг ашиглах /бүлэглэн шилжүүлэн/ санал бэлтгэх
- захирагдсан салбаруудыг зайлшгүй шаардлагатай материал, техник хэрэгслээр хангах талаар арга хэмжээ авах
- өгөгдсөн үүргийн биелэлтийн үр дүн, явцын талаар мэдээ бэлтгэх
- гаргаж байгаа шийдвэрийг бие бүрэлдэхүүнд хүргэж, түүний биелэлтэнд хяналт тавих
- төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон орон нутгийн байгууллагуудын харилцан ажиллагааг хангах
- харилцан ажиллагаатай байгууллагуудыг нөхцөл байдлын өөрчлөлтийн талаар мэдээлэх, зайлшгүй нэмэгдэл хамтран ажиллах ажиллагааг хэрэгжүүлэх,
- шуурхай штабыг бэлтгэх бэлэн байлгаж түүний үйл ажиллагааг зохион байгуулж удирдах зэрэг арга хэмжээг авах зохимжтой юм.

Хорих ангид байгуулагдаж байгаа энэхүү “шуурхай штаб”-ын онцлог нь зөвхөн онцгой нөхцөл байдлын үед хорих ангийн даргын шийдвэрээр байгуулагдаж шуурхай штаб нь өөрийн үндсэн үүргээ хэрэгжүүлэхэд штабын бүрэлдэхүүн онцгой үүрэгтэй бөгөөд энэхүү бүрэлдэхүүнд хорих ангид хорих ангийн дарга, ГАХХ эрхэлсэн дэд дарга, санхүү, үйлдвэр эрхэлсэн дэд дарга, ахлах нийгмийн ажилтан, гадна харуул хамгаалалтын офицер, ахлах төлөөлөгч, төлөөлөгч, холбооны техникч, бичиг хэргийн эрхлэгч нарыг оролцуулах нь зохистой байдаг.

Шуурхай штабын дарга нь хорих ангийн дарга байх бөгөөд штабын бүх ажлыг удирдаж, бүлгүүдийг тогтвортой, тасралтгүй, шуурхай удирдлагаар хангаж, бүлгүүдийн бэлэн байдлыг хариуцан, нийт бие бүрэлдэхүүний бүрдэлт, сэтгэл зүйн бэлтгэл, өндөр сахилга бат, ёс суртахууны байдал, зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтыг хариуцна. Штабын даргын орлогчоор хорих ангийн ГАХХ эрхэлсэн дэд дарга ажиллана.

Шуурхай штабын дарга нь онцгой нөхцөл байдалын үед дараах үүргүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- захирагдсан бүлгүүдийн хүч, хэрэгсэл, хангалт хийх боломж, техник хэрэгслийн тооцоо, хамтран ажиллах байгууллагуудын хүч, хэрэгслийн судалгааг байнга мэдэх,
- шаардлагатай мэдээ мэдээллийг цуглуулах ажлыг зохион байгуулах, тэдгээрийг дүн шилжилгээ хийж нэгтгэх
- дээд шатны байгууллагад нөхцөл байдлын талаар өөрийн дүгнэлтийг илтгэхэд бэлтгэх
- шуурхай штабын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих
- бие бүрэлдэхүүнд сургалт явуулах, ажиллагааны талаар зөвлөмж хүргэх, шууд захирагдсан бүлгүүдийн бэлэн байдлын бэлтгэл хангуулах,
- холбооны техник, хэрэгслийн бэлэн байдлыг шалгах,
- бие бүрэлдэхүүн удирдлагын шаардлагыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих,

- шуурхай ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр ирсэн хүч, хэрэгслийг бүлгүүдэд хуваарилах

- хамтран ажиллаж байгаа байгуулагуудад өөрийн бүлгүүдийн таних тэмдэг, дохиог болон цагийн байдлын талаарх мэдээг хүргүүлэх,

- шуурхай штабын гишүүдийн бэлтгэл болон тэдгээрийн үүрэг гүйцэтгэлд хяналт тавих үндсэн үүргийг хэрэгжүүлэхээс гадна үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан бусад үүргийг мөн хэрэгжүүлдэг.

Шуурхай штабын даргын орлогч нь Штабын даргад захирагдан түүний эзгүйд орлон үлдэж, үүргийг нь гүйцэтгэх, шаардлагатай тооцоо лавлагаануудыг бэлтгэх, ГА-ын шугамаар авах мэдээ, мэдээллийг цуглуулах, төлөөлөгч нарын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, чиглэл өгөх, хорих ангийн харуул хамгаалтыг зохион байгуулах, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх, тусгай бүлгийн бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагааг удирдах, галт зэвсэг, тусгай хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд хяналт тавих, ялтны тоо бүртгэлийн бүлгийг удирдан зохион байгуулах үүрэгтэй.

Санхүү үйлдвэр эрхэлсэн дэд дарга нь авто машин, өөрөө явагч техник хэрэгслийн бүрэн бүтэн, бэлэн байдлыг хангуулан үүргийн хэрэгжилт, шаардлагатай бараа материалын нөөцийг бүрдүүлэх, шатах, тослох материалын зарцуулалтанд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол хийлгэх, хүнсний нөөцийн тооцоог хянах, нөөцийг бүрдүүлэх, цахилгааны найдвартай байдлыг хангуулах, бүлгүүдийн хангалтыг зохион байгуулах, цэвэр усны хангалт хийх, аюулгүй байдлыг хангах, захирагдсан бүлгийн үүргийн биелэлтэнд хяналт тавих, ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийг бүрдүүлэх, нийт ажиллагааны зардлын тооцоог хөтлөх, хохирлыг тооцох, нөөц техник, хэрэгслийн тооцоог гарган ажиллах ёстой.

Ахлах төлөөлөгч нь төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангуулах, ГА-ын шугамаар олж авах, мэдээ, мэдээллийн найдвартай, аюулгүй байдлыг хангах, мэдээ, мэдээллийг бататгах, болзошгүй аюулын талаар удирдлагад мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг авахуулах, ялтны сэтгэл зүйн байдалд хяналт тавих, нөлөөлөл үзүүлэх чиглэлийг тодорхойлон зохих бүлгүүдийг удирдан чиглүүлэх, хорих ангийн аюулгүй байдалд хяналт тавих, зөрчил, дутагдлыг тухай бүр засч арилгуулах, ээлжийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлд хяналт тавих, тодорхой үүрэг чиглэл өгнө.

Ахлах нийгмийн ажилтан нь ялтанд сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх, багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ялтны зүгээс үзүүлж байгаа аливаа эерэг, сөрөг үйлдлийн талаарх мэдээллээр хангах, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн өөрчлөлтөнд хяналт тавих, сэтгэл зүйн бэлтгэжилт хийлгэх, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах, ялтны болон бие бүрэлдэхүүний хоол, эрүүл мэнд, эрүүл ахуй, ариун цэвэр, орчин нөхцөлд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээнүүдийг авах, эмнэлгийн бүлгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг хүлээн.

Холбооны техникч нь холбоочдын гүйцэтгэх үүргийг хуваарилах, холбооны техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, нөөц хэрэгслийг бэлэн байдалд оруулах, тодорхой ажиллагаанд холбооны гүйцэтгэх үүргийн талаар төлөвлөгөө боловсруулахад оролцох, бие бүрэлдэхүүнд өөрийн мэргэжлээр хичээл явуулах, холбоочдын үүрэг гүйцэтгэх чадварыг мэдэж байх, бүлгүүдийн хоорондох холбооны

найдвартай тасралтгүй байдлыг хангах, холбооны үелзлэлийн нууцлалыг хангах, бүлгүүдээс ирэх мэдээ, мэдээллийг нарывчлан бүртгэж хөтлоход хяналт тавих, мэдээ, мэдээллийг шуурхай танилцуулах ажиллагааг зохион байгуулах, удирдлагаас гарсан шийдвэрийг бүлгүүд болон хамтран ажиллаж байгаа байгууллага нэгжүүдэд хүргүүлэх ажлыг гүйцэтгэх, техник хэрэгслийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, тухай бүр үзлэг хийх, баримтжуулалтын бүлгийн техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хяналтын камеруудын найдвартай байдлыг ханган, гэмтлийг тухай бүр засварлах, шаардлагатай байршилд техник, хэрэгслийг байршуулах зэрэг үүргүүдийг хэрэгжүүлэгч гол гишүүн байдаг.

Бичиг хэргийн эрхлэгч нь Шуурхай штабын даргад захирагдан шаардлагатай эрх зүйн актын сангаар удирдлагын бүлгийг хангах, боловсруулагдсан болон дээд шатны байгууллагаас хүлээн авсан баримт бичгүүдийг зааврын үндсэн дээр зөв хадгалах, боловсруулагдсан баримт бичгийн нууцлалыг хангах, шаардагдах баримт бичгийг цаг тухайд нь зөв чадварлаг боловсруулах шуурхай штабын дарга болон орлогчоос амаар болон бичгээр өгсөн үүргүүдийн бүртгэл хөтлөх, удирдлагын бүлгийн ажиллах нөхцлийг хангана.

Практик амьдрал дээр хорих ангийн хэмжээнд “Онцгой нөхцөл байдал” үүссэн үед тухайн цагт үүрэг гүйцэтгэж байгаа жижүүрийн бүрэлдэхүүнээс авч хэрэгжүүлж байгаа ажиллагааны ач холбогдол асар өндөр байдаг. Учир нь “Шуурхай штаб” байгуулагдах хүртэлх хугацаанд ээлжийн дарга, ерөнхий жижүүр нь болж буй нөхцөл байдалд үнэлэлт өгч, нэн тэргүүнд авагдах арга хэмжээнүүдийг удирдамжинд заагдсанаар бие даан хэрэгжүүлэх, бие бүрэлдэхүүнийг цугларалтаар дуудах, шаардлагатай мэдээллийг цуглуулах, хорих ангийн аюулгүй байдлыг хангах зэрэг үүргүүдийг хэрэгжүүлдэгтэй холбоотой.

Иймээс ерөнхий жижүүр, ээлжийн даргыг томилохдоо онцгой нөхцөл байдалд бие бүрэлдэхүүнийг удирдан ажиллах чадвартай, сэтгэл зүй, бие бялдрын хувьд бэлтгэгдсэн алба хаагчийг сонгох шаардлага урган гарч байна.

Түүнээс гадна хорих ангид онцгой нөхцөл байдал үүссэн үед зохион байгуулагдах шуурхай штабын гишүүд болон бүлгүүдийн үүрэг оролцоог цаашид нарывчлан судалж тогтоосноор ажил үүргийн давхардал, хийдлийг арилгаж, оролцогчдын гүйцэтгэх үүрэг тодорхой болж, удирдлагын шуурхай байдлыг ханган аюулыг хохирол багатайгаар даван гарах үндэс болно.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
хошууч Ч.Цэнгэлбаяр*

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ НИЙГМИЙН АЖИЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

1990-ээд оны улс төр, эдийн засгийн өөрчлөлтүүд нийгмийн олон асуудлыг бий болгож тэдгээрийг шийдвэрлэх тогтолцоо, үйлчилгээ, мэргэжилтэнг бэлтгэх хэрэгцээг төрүүлсэн нь нийгмийн ажилтны мэргэжил бий болох нөхцөлийг